



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А-45

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалт, Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монголбанкны авлигаас урьдчилан сэргийлэх 2015 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох газар (хэлтэс, алба, төв), нэгжийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т даалгасугай.


ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

4 : 0310

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн
А... дугаар тушаалын хавсралт



МОНГОЛБАНКНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ 2015 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийх ажлын агуулга	Эрх зүйн үндэслэл	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хариуцан гүйцэтгэх нэгж, ажилтан	Гүйцэтгэх хугацаа	Биелэлт
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	-Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 9 дүгээр зүйлийн 9.1.2	1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	Жилийн турш	
			1.2.АТГ-аас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг бүртгэл хөтлөн ажилтнуудад түгээх	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	Тухай бүр	
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5	2.1.Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг Монголбанкны цахим хуудсанд байрлуулж, санал шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх, үндэслэлтэй гэж үзвэл саналыг төсөлд тусгах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	холбогдох нэгж, ХЭЗГ, Г.Эрдэнэбаяр	Тухай бүр	

3.	Хяналт шалгалтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3	3.1.Хяналт шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ерөнхий мэдээлэл өгөх	ХШГ, Д.Ганбат, Д.Батмөнх	Улирал бүр	
4.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, -Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл	4.1.Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны өдрийн дотор/-ийг цахим хуудсанд байршуулах	ТГ, Г.Байгалмаа	Хуульд заасан хугацаанд	
			4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайланг 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор цахим хуудсанд байршуулах /хуулийн 6.1.4/	ТТБГ, М.Амгалан, Д.Намжилсүрэн Ц.Гарьд	Хуульд заасан хугацаанд	
			4.3.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах /хуулийн 6.1.5/	ДХҮАЭГ, Х.Дэлгэр, ТТБГ, М.Амгалан, Д.Намжилсүрэн Ц.Гарьд	Хуульд заасан хугацаанд	
			4.4.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор/	ТГ, Г.Байгалмаа	Хуульд заасан хугацаанд	
			4.5.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	ТТБГ, М.Амгалан, О.Бадамцоо, А.Баярсайхан	Хуульд заасан хугацаанд	

			4.6.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах	Холбогдох нэгж	Хуульд заасан хугацаанд	
5.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8	5.1.Байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гм бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	ХШГ, Д.Ганбат, А.Туул, ТТБГ, М.Амгалан, Т.Амарсайхан	2 дугаар сард багтаан	
			5.2.Дээрх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	ХШГ, Д.Ганбат, А.Туул, ТТБГ, М.Амгалан, Т.Амарсайхан	2 дугаар сард багтаан	
			5.3.Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	ХШГ, Д.Ганбат, А.Туул, ТТБГ, М.Амгалан, Т.Амарсайхан	2 дугаар сард багтаан	
			5.4.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох	ХШГ, Д.Ганбат, А.Туул, ТТБГ, М.Амгалан, Т.Амарсайхан	2 дугаар сард багтаан	

6.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл	6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах	ТГ, П.Эрдэнэтуяа, Д.Бурмаа, Л.Намхай	Тухай бүр	
			6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	ТГ, П.Эрдэнэтуяа, Д.Бурмаа, Л.Намхай	Тухай бүр	
7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; -Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5	7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш 1 сарын дотор цахим хуудсандаа байршуулах	ТГ, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа	Хуульд заасан хугацаанд тухай бүр	
			7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах	ТГ, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа	Тухай бүр	
			7.3.Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх	ТГ, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа	Тухай бүр	
			7.4.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах	ТГ, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа	Тухай бүр	
			7.5.Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх	ТГ, ҮААХ, Д.Нармандах, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа	Хуульд заасан хугацаанд	

			7.6.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлт болон хяналт шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	ДХҮАЭГ, Х.Дэлгэр	Хуульд заасан хугацаанд	
			7.7.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	ТГ, Э.Эрдэнэхишиг, Б.Гаваа		
8.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6	8.1.Ажилтан нэг бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлсэн байх	ТГ, П.Эрдэнэтуяа, Д.Бурмаа, Л.Намхай	2 дугаар улиралд багтаан	
			8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	ТГ, П.Эрдэнэтуяа, Д.Бурмаа, Л.Намхай	2 дугаар сард багтаан	
9.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13, -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3	9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх	Холбогдох нэгж	Тухай бүр	
			9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	Хуульд заасан хугацаанд	
			9.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх	ТГ, ОНХХ, Ю.Гэрэлтуяа	Тухай бүр	

10	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах</p>	<p>-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, -Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2</p>	<p>10.1.АТГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх, ЭБАТ-ны үйл ажиллагааг үнэлэх</p>	<p>ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг</p>	<p>Тухай бүр</p>	
			<p>10.2.Авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан ажилтан /ЭБАТ/-ыг чадавхижуулан авлигын эсрэг хууль тогтоомжийг байгууллага, салбар нэгжийн хүрээнд сурталчлах, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах</p>	<p>ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг,</p>	<p>Тухай бүр</p>	
11	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх</p>	<p>-Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл -Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6</p>	<p>11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх</p>	<p>ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг</p>	<p>1 дүгээр сард багтаан</p>	

			11.2.Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/	ТГ, Д.Чимэд-Юндэн	Жилийн турш	
			11.3.Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх	Монголбанкны Ёс зүйн хороо	Жилийн турш	
			11.4.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /зөвлөмж/-г авах	Монголбанкны Ёс зүйн хороо	Жилийн турш	
			11.5.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	ТГ, Монголбанкны Ёс зүйн хороо	Жилийн турш	
			11.6.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	Монголбанкны Ёс зүйн хороо	Жилийн турш	
12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл	12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	2 дугаар улиралд	
			12.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	2 дугаар улиралд	
13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10,	13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/	ХЭЗГ, Г.Эрдэнэбаяр, холбогдох нэгж	Хуульд заасан хугацаанд	

		-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5			
			13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах	ХЭЗГ, Г.Эрдэнэбаяр, ТГ, М.Халиунаа	Хуульд заасан хугацаанд
			13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	ХЭЗГ, Г.Эрдэнэбаяр	Хуульд заасан хугацаанд
			13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах	ТТБГ, М.Амгалан, Т.Амарсайхан, ХШГ, Д.Ганбат, ТГ, Ц.Мөнхтуяа, Ч.Цолмонтуяа	Хуульд заасан хугацаанд
14	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11, -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, -Нийтийн албанд нийтийн болон хувийн	14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх	Тамгын газар, ОНХХ	Жилийн турш

		<p>ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3,</p> <p>-Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг</p>				
			14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м/	ТГ, П.Эрдэнэтуяа, Б.Сэлэнгэ, М.Тулга	Жилийн турш	
			14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	ТГ, Э.Эрдэнэхишиг, Ч.Эрдэнэчулуун, Б.Сэлэнгэ	2 дугаар сард багтаан	
			14.4.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр /цахим хуудсанд/ тогтмол хугацаанд мэдээлсэн байх	ТГ, Б.Сэлэнгэ	Улирал бүр	

15	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1	15.1.“Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын 9.1.15.1-д заасан жагсаалтыг гаргах	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	1 дүгээр улиралд	
			15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	Жилийн турш	
16	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4, -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2	16.1.АТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийг зохион байгуулж, арга хэмжээ авсан байх	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	Тухай бүр	
			16.2.АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг, холбогдох нэгж	Тухай бүр	

			16.3.АТГ-аас хариуцлага тооцож арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт	ТГ, П.Эрдэнэтуяа, Д.Бурмаа, Л.Намхай, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	Тухай бүр	
17	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх		17.1.Албан тушаалтан, ажилтнуудын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	ТГ, Ч.Эрдэнэчулуун, Э.Эрдэнэхишиг	2 дугаар улиралд	

